



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

**АХУЙН ЗОРИУЛАЛТААР СААРАЛ ЧОНО АГНАХТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ  
ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
*/Ховд аймгийн хүрээнд/*

Улаанбаатар хот  
2023 он

<b>АГУУЛГА</b>	<b>Хуудасны дугаар</b>
<b>ЭХ СУРВАЛЖ</b>	3
<b>НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ</b>	4-6
<b>ХОЁР.АХУЙН ЗОРИУЛАЛТААР СААРАЛ ЧОНО АГНАХТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ</b>	
2.1.Ховд аймгийн хэмжээнд чонын тоо хэмжээг тогтоосон эсэх талаар	7-9
2.2.Чоно агнах зөвшөөрөл, төлбөр болон төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтын хэрэгжилтийн байдал	9-12
2.3.Зөвшөөрөлгүй чоно агнасан зөрчил, түүнийг хэрхэн шийдвэрлэж буй талаар	12
2.4.Галт зэвсгийн зөвшөөрөл болон зөвшөөрөлгүй галт зэвсэг ашиглан чоно агнасан зөрчлийн талаар	13-15
2.5.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон ангийн аж ахуй эрхэлдэг мэргэжлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны талаар	15-16
<b>ГУРАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>	16-18

## ЭХ СУРВАЛЖ

### Эрх зүйн эх сурвалж:

1. Амьтны тухай хууль 2012 он;
2. Байгалийн нөөц ашигласны тухай хууль 2012 он;
3. Галт зэвсгийн тухай хууль 2015 он;
4. Зөрчлийн тухай хууль 2017 он;
5. Зөвшөөрлийн тухай хууль 2022 он;
6. Засгийн газрын 2011 оны “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоол;
7. Засгийн газрын 2012 оны “Жагсаалт, журам батлах тухай (ховор амьтны)” 7 дугаар тогтоол;
8. Засгийн газрын 2023 оны “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоол;
9. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/89 дүгээр тушаал;
10. Ховд аймгийн Засаг даргын 2022 оны А/464 дугаар захирамж;
11. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”.

### Бусад эх сурвалж:

1. Ховд аймгийн ан агнуурын 2012, 2017, 2022 оны менежментийн төлөвлөгөө;
2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Улсын Их Хурлын Тамгын газарт цахимаар ирүүлсэн статистик мэдээлэл;
3. Ховд аймгийн Засаг даргын 2023 оны 1/212 дугаартай албан бичгээр сумдад хүргүүлсэн зөвлөмж;
4. Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 123 дугаартай албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн ирүүлсэн мэдээлэл;
5. Ховд аймгийн Цагдаагийн газрын Галт зэвсгийн бүртгэл хариуцсан албан тушаалтнаас Улсын Их Хурлын Тамгын газарт цахимаар ирүүлсэн мэдээлэл;
6. Улсын Их Хурлын Тамгын газраас Ховд аймгийн малчин иргэдээс утсаар холбогдож авсан мэдээлэл.

## НЭГ.ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

### Үнэлгээ хийх болсон шалтгаан, үндэслэл:

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн УИХ-03/2325 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т "...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно." гэж заасныг тус тус үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газраас ахуйн зориулалтаар саарал чоно /Цаашид "чоно" гэх/<sup>1</sup> агнах харилцааг зохицуулж буй хуулиудын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлээ.

Үнэлгээг хийхдээ Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн албан хүсэлтэд дурдсан дараах шалтгааныг тогтооход чиглэсэн болно. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан "мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах" заалт хэрэгжиж байгаа эсэх, гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар;
- Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан "Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно" гэсэн нь бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх;
- Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан зохицуулалтаар хариуцлага хүлээсэн иргэнд гарцаагүй нөхцөл байдлын улмаас чоно агнасан тохиолдолд хэрхэх талаар;
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймаг, орон нутгийн удирдлага нь ангийн аж ахуй эрхэлдэг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа эсэх талаар.

### Үнэлгээний зорилго:

Ахуйн зориулалтаар чоно агнахтай холбоотой харилцааг зохицуулж буй хуулиудын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж, цаашид тухайн харилцааг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойллоо.

### Үнэлгээний аргалал:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу үнэллээ.

### Үнэлгээ хийх хүрээ:

Үнэлгээг дараах хуулиудын холбогдох зүйл, хэсгийн хүрээнд тодорхойлж, хэрэгжилтийн байдлыг Ховд аймгийн хэмжээнд гаргасан. Үүнд:

<sup>1</sup> "Саарал чоно"-ын латин нэршил нь "Canis lupus"

Хуулийн нэр	Үнэлэх зүйл, хэсэг, заалт
АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ	<b>5 дугаар зүйл.</b> Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар төрийн болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх <b>26 дугаар зүйл.</b> Агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох <b>28 дугаар зүйл.</b> Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих <b>35 дугаар зүйл.</b> Амьтны тоо толгойг зохицуулах
БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ	<b>12 дугаар зүйл.</b> Ан амьтны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт <b>17 дугаар зүйл.</b> Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ <b>22 дугаар зүйл.</b> Ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх
ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬ	<b>9 дүгээр зүйл.</b> Галт зэвсэг өмчлөх <b>11 дүгээр зүйл.</b> Галт зэвсэг ашиглах
ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ	<b>5.6 дугаар зүйл.</b> Хууль бусаар зэвсэг эзэмших <b>7.6 дугаар зүйл.</b> Амьтны тухай хууль зөрчих

**Үнэлгээний шалгуур үзүүлэлт:**

Үнэлгээний хүрээ, онцлогоос шалтгаалан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс тус харилцааг зохицуулж буй холбогдох хуулиудын үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон. Үүнд:

- **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал:** Шалгуур үзүүлэлт нь иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.
- **Практикт нийцэж байгаа байдал:** Шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагаврыг энэхүү шалгуур үзүүлэлтээр шалгана.

**Үнэлгээний харьцуулах хэлбэр:**

Тухайн харилцааг зохицуулж буй хуулиудын өнөөгийн нөхцөл байдал болон гарсан үр дүнг харьцуулах, мөн практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор “*байх ёстой болон одоо байгаа нөхцөлийг судлах*”, “*тохиолдол судлах*” гэсэн үнэлгээний харьцуулах хэлбэрүүдийг сонгосон.

Харьцуулах хэлбэр	Тодорхойлолт
Байх ёстой болон одоо байгаа	хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулиар тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.

Тохиолдол судлал	хууль эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй зүйл, хэсэг өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулна.
------------------	--

**Үнэлгээний асуулт:**

Үнэлгээний шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэртэй уялдуулан дараах үнэлгээний асуултыг боловсруулсан. Үүнд:

- **Үнэлгээний асуулт 1.**Ховд аймгийн хэмжээнд чонын тоо хэмжээг тогтоосон эсэх?
- **Үнэлгээний асуулт 2.**Чоно агнах зөвшөөрөл, төлбөр болон төлбөрөөс чөлөөлөх зохицуулалт хэрэгжиж байна уу?
- **Үнэлгээний асуулт 3.**Зөвшөөрөлгүй чоно агнасан зөрчил, түүнийг шийдвэрлэх зохицуулалт хэрэгжиж байгаа эсэх?
- **Үнэлгээний асуулт 4.**Галт зэвсгийн зөвшөөрөл болон зөвшөөрөлгүй галт зэвсгээр чоно агнасан зөрчил бүртгэгддэг үү?
- **Үнэлгээний асуулт 5.**Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ангийн аж ахуй эрхэлдэг мэргэжлийн байгууллагатай хамтран ажилладаг эсэх?

**Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар:**

Үнэлгээ хийхэд шаардлагатай тоон болон чанарын мэдээллийг дараах аргаар цуглуулж ашигласан болно. Үүнд:

- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааны тайлан, статистик тоо баримтыг ашигласан.
- **Холбогдох субъектүүдээс мэдээлэл, судалгаа авах:** Төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа Төрийн захиргааны төв байгууллага болон Ховд аймгийн төрийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагаас албан бичгээр мэдээллийг цуглуулсан.
- **Тохиолдол судлах:** Тус үнэлгээ нь Монгол Улсын Их Хурлын төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын цаглаварт тусгагдаагүй, мөн цаг хугацаа болон хүний нөөцийн хувьд хязгаарлагдмал байсан тул Ховд аймагт ажиллаагүй болно. Иймд Ховд аймгийн төрийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагын удирдлага, албан тушаалтан болон Ховд аймгийн зарим малчин иргэдтэй утсаар ярилцаж үнэлгээний асуулт, шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл цуглуулсан болно.

**Үнэлгээ хийсэн бүрэлдэхүүн хугацаа:**

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг хянан удирдаж, зөвлөх Б.Нандингэрэл, референт Б.Буянзаяа, Г.Чингүнжав нар 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 09 дүгээр сарын 29-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

## ХОЁР.АХУЙН ЗОРИУЛАЛТААР СААРАЛ ЧОНО АГНАХТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний баг ахуйн зориулалтаар чоно агнахтай холбоотой харилцааг зохицуулж буй Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг сонгож үнэлгээний асуултын дагуу тайланг боловсруулсан болно.

### 2.1.ХОВД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЧОНЫН ТОО ХЭМЖЭЭГ ТОГТООСОН ЭСЭХ ТАЛААР

Монгол Улсад 1986 оны байдлаар 30 гаруй мянган чоно 18 аймгийн нутаг дэвсгэрт тархсан гэж Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн эрдэмтдийн гаргасан судалгаанд дурджээ. Үүнээс хойш улсын хэмжээнд чонын талаар нарийвчлан судалсан судалгаа, мэдээлэл байхгүй байна.

Амьтны тухай хууль 2012 онд батлагдсанаар бүс нутгийн амьтны зүйлийн бүрдэл, тэдгээрийн тархац, нөөцийн судалгааг хийж зэрлэг амьтны мэдээллийн санг тогтмол шинэчилсний үндсэн дээр зэрлэг амьтныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Иймээс үнэлгээ хийх хүрээнд Ховд аймгийн хэмжээнд чонын тоо хэмжээ, нөөцийг судлан тогтоож ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгасан эсэхийг хянан үзлээ.

**Ан агнуурын менежментийн төлөвлөгөө:** Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-д "ан агнуурын менежментийн төлөвлөгөө гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг" хэлнэ гэж заасан. Тус менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа "агнуурын зохион байгуулалт"<sup>2</sup>-ын ажлыг гүйцэтгэсний үндсэн дээр боловсруулдаг.

Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.1-д "агнуурын нөөц, түүний тооллого бүртгэл, агнуур зохион байгуулалтын ажлыг улс, орон нутгийн болон иргэн, хуулийн этгээдийн захиалга, хөрөнгөөр гүйцэтгэх, тэдгээрийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах" гэж, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ агнуур зохион байгуулалтыг таван жил тутамд хийлгэж..." гэж тус тус заасны дагуу Ховд аймгийн 2012-2016, 2017-2021 оны менежментийн төлөвлөгөөг тус аймгийн захиалга, хөрөнгөөр холбогдох мэргэжлийн байгууллага боловсруулж иржээ.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2-т "агнуурын нөөц бүхий аймаг болон ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих" гэж заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тус аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт хяналт тавьж байна.

Мэргэжлийн байгууллагаас Ховд аймгийн 2012-2016, 2017-2021 оны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Ховор амьтны жагсаалт"-д багтсан "аргаль хонь", "янгир ямаа" болон "монгол тарвага" зэрэг амьтдыг сонгож, эдгээр амьтдын экологи, эдийн засгийн үнэлгээ, тоо

<sup>2</sup> "Агнуурын зохион байгуулалт" гэж агнуурын амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагаа юм.

толгой, тэдгээрийн тархац, нөөц, сүргийн бүтэц, насны ангилал, үржлийн чадавх, хүйсийн харьцаа зэргийг тогтоожээ.

Хамгийн сүүлд Ховд аймгийн 2022-2026 оны ерөнхий агнуурын зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ байгууллага гүйцэтгэн боловсруулсан бөгөөд одоогоор тус менежментийн төлөвлөгөөг батлуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлжээ. Тус ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд мөн дээр дурдсан “аргаль хонь”, “янгир ямаа” болон “Монгол тарвага” зэрэг амьтдыг тусгасан байна.

Үүнээс үзэхэд, Ховд аймгийн хэмжээнд Амьтны тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө болон дараа чонын тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх талаарх судалгаа хийгээгүй байна.

**Тухайн жилд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоосон байдал:** Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагаас тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг, энэ хуулийн 5.3.2, 5.8.1-д заасан буюу ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгасан агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтоодог.

2022 оны байдлаар Ховд аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд чонын тоо хэмжээ, нөөцийг судлан тогтоож тусгаагүй боловч Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2021 оны 317 дугаартай албан бичгээр “2022 онд Ховд аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар агнах, барих чонын тоо хэмжээг 50 байх” саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна.

Тус саналын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/89 дүгээр тушаалын хавсралтаар 2022 онд Ховд аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар агнах, барих чонын тооны дээд хязгаарыг 50 байхаар тогтоож баталсан байна.

**Хүснэгт 1.** Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан “Ахуйн зориулалтаар агнах, барих чоно”-ын тоо хэмжээ

№	Аймгийн нэр	Нөөцөө тогтоосон эсэх	2021	2022	2023
1.	Архангай	2134±346	30	10	49
2.	Баян-Өлгий	-	-	40	30
3.	Булган	-	-	-	15
4.	Баянхонгор	-	-	-	5
5.	Говь-Алтай	-	-	-	90
6.	Дархан	38	-	10	10
7.	Завхан	-	15	-	5
8.	Өвөрхангай	-	-	30	25
9.	Сэлэнгэ	-	30	20	20
10.	Төв	-	4	4	21
11.	Хэнтий	2951	11	-	20
12.	Ховд	-	-	<b>50</b>	-
13.	Увс	-	-	-	5
<b>Нийт дүн</b>		-	<b>90</b>	<b>164</b>	<b>295</b>



Дээрх судалгаанаас үзэхэд, Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт хамаарах дараах хуулийн хэсэг, заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

1. Өнгөрсөн хугацаанд Ховд аймгийн хэмжээнд чонын тоо хэмжээ, нөөцийг судлан тогтоож байсан тодорхой баримт, мэдээлэл байхгүй буюу чонын тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх судалгааг хийгээгүй байна. Тухайлбал, 2012 оноос хэрэгжиж эхэлсэн Амьтны тухай хуульд заасны дагуу Ховд аймгийн ан агнуурын 2012-2016, 2017-2021, 2022-2026 оны агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд чонын тоо хэмжээ, нөөцийг судлан тогтоож тусгаагүй байна.
2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/89 дүгээр тушаалаар 2022 онд тус аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар агнах, барих чонын тооны дээд хязгаарыг 50 байхаар тогтоосон нь Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасан “Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг, энэ хуулийн 5.3.2, 5.8.1-д заасан агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.” гэсэн шаардлагыг хангаагүй байна.
3. Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2-т заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам ан агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Гэвч тус аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд чонын тоо хэмжээ, нөөцийг тогтоож тусгаагүй байхад Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын саналыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар тус аймгийн тухайн жилд агнах, барих чонын дээд хязгаарыг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуульд заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
4. Ховд аймгийн хэмжээнд чонын тоо хэмжээ, нөөцийг тогтоогоогүй нь Амьтны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.12-т заасан “эрх бүхий мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалтын ажлыг хуульд заасан хугацаанд нь хийлгээгүй аймаг, сум, нийслэл, дүүргийн нутагт агнуурын амьтан агнах, барих”-ыг хориглох заалтын үйлчлэлд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, Ховд аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар чоно агнах, барих хуульд заасан нөхцөл бүрдээгүй байна.

## **2.2.ЧОНО АГНАХ ЗӨВШӨӨРӨЛ, ТӨЛБӨР БОЛОН ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**

**Ахуйн зориулалтаар чоно агнах, барих зөвшөөрөл олгох:** Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалыг<sup>3</sup> үндэслэн Ховд аймгийн Засаг даргын 2022 оны А/464 дүгээр захирамжаар 2022 онд аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар агнах, барих чонын тоо хэмжээний дээд хязгаарыг мөн баталжээ. Тус захирамжийн хүрээнд Ховд аймгийн 16 сум тус бүрд 3 чоно агнах дээд хязгаарыг тогтоосон. Гэвч тус захирамжийн дагуу чоно агнасан, барьсан талаар холбогдох төрийн байгууллагад бүртгэгдээгүй байна. Энэ талаар Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох албан тушаалтан *“Нэг чоно агнахад төлөх төлбөрийн хэмжээ өндөр байгаа тул иргэд чонын авыг зохион байгуулаагүй.”* гэж тайлбар ирүүлсэн байна.

<sup>3</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны “Ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаар батлах тухай” А/89 дүгээр тушаал

Иймд тус аймгийн удирдлагаас чоно агнах, барих төлбөрөөс тодорхой хугацаанд чөлөөлөх шийдвэрийг гаргасан бөгөөд тодруулбал, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/212 дугаар албан бичгээр сумдын Засаг дарга нарт 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл чоныг төлбөргүй агнах зөвлөмжийг хүргүүлсэн байна. Тус зөвлөмжийн хүрээнд Ховд аймгийн Мөст суманд 3, Үенч суманд 1 нийт 4 чоныг заасан хугацаанд төлбөргүй агнасан байна.

**Иргэн ахуйн зориулалтаар чоно агнах, барих зөвшөөрөл авах:** Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас олгосон эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд тус эрхийн бичигт иргэний овог, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заадаг. Тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.2-т заасны дагуу чоно агнах, барих зөвшөөрлийг тав хүртэл хоногийн хугацаатай олгодог байна.

Мөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.2-д тус тус заасны дагуу Засгийн газрын 2023 оны “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолыг үндэслэн тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 226,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 22,600 төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 248,600 төгрөгийн үнэлгээтэй байна.<sup>4</sup>

Ховд аймгийн зарим иргэд, малчидтай утсаар холбогдож хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл авсан бөгөөд чоно агнах төлбөр, зөвшөөрөлтэй холбоотой дараах агуулга бүхий тайлбар, мэдээллийг өгсөн болно.

- *Нэгдүгээрт, ан агнах зөвшөөрлийн бичиг нь тав хүртэлх хоногийн хугацаатай байдаг бөгөөд хэрэв тухайн хугацаанд ан хийж чадаагүй бол дахин зөвшөөрөл авах шаардлага үүсдэг тул төлбөр төлж зөвшөөрөл авах сонирхолгүй байдаг.*
- *Хоёрдугаарт, хуульд заасны дагуу ан агнах зөвшөөрөл авахад шаардлагатай баримт бичиг бүрдүүлэх нь малчин иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг бөгөөд тухайлбал, ангийн буу өмчлөх, эзэмших зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг.*
- *Гуравдугаарт, малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнасан ч ямар нэгэн торгууль шийтгэл хүлээж байгаагүй талаар дурдсан болно.*

*“Манайхан малаа байнга л дагаж явдаг. Эзэнгүй орхивол чоно дайрах нь элбэг байдаг. Харин хоттой хонь руу чоно дайрсан тохиолдол одоогоор байхгүй. Бид ямар нэгэн байдлаар малаа хамгаалж чоно агнасан ч торгууль, шийтгэл хүлээдэггүй. Өмнө нь чоно ихэссэн үед гол усаараа нийлж чоно агнадаг байсан. Тэр үед чоно агнасан хүмүүсийг айл болгон нэг хониор шагнадаг байлаа. Одоо тийм зүйл байхгүй. Харин ганц нэгээрээ чоно агнадаг тохиолдол байгаа. Ан ав зохион байгуулаад албан ёсоор агнаад үргээгээд өгвөл бидэнд их тустай л байна.”*

*Ховд аймгийн Үенч сумын иргэн Э...*

**Зөвшөөрлийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн эсэх:** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн эсэх

<sup>4</sup> Засгийн газрын 2011 оны “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолын дагуу чоно агнах зөвшөөрлийн төлбөрийг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 102,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 10,200 төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 112,200 төгрөгийн үнэлгээтэй байсан.

талаар холбогдох төрийн байгууллагаас тодруулахад, Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 123 дугаартай албан бичгээр “агналт хийгдээгүй учраас төлбөр төвлөрөөгүй” талаар тайлбар ирүүлсэн.

**Төлбөрөөс чөлөөлөх нөхцөл:** Үнэлгээний энэ хэсэгт чоно агнахад төлбөрөөс чөлөөлөх нөхцөл, түүний хэрэгжилтийн талаар хянан үзсэн бөгөөд дараах хуулийн зохицуулалтын хүрээнд чоно агнах төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болдог байна. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах”;
- Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан “Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно” гэсэн хэсэг, заалтууд байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д заасан “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх..” нөхцөлийг тогтохдоо Амьтны тухай хуульд заасны дагуу тухайн амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлж тухайн аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгасан байх хуулийн зохицуулалттай. Гэвч Ховд аймгийн хүрээнд дээрх судалгаа, нөөцийг тогтоох ажил хийгдээгүй боловч тус заалтыг үндэслэн Ховд аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/212 дугаартай албан бичгээр төлбөргүй чоно агнах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн байна.

Харин Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно” гэж заасан бөгөөд өнгөрсөн хугацаанд тус аймгийн мэргэжлийн байгууллагад чонотой холбоотой дээрх нөхцөл тогтоогдож бүртгэгдсэн тохиолдол байхгүй байна.

Иймд, Амьтны тухай хууль болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан ахуйн зориулалтаар ан агнах зөвшөөрөл, төлбөрийн харилцааг зохицуулсан зарим зүйл, заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь дараах шалтгаантай гэж үзэж байна.

1. Ховд Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/212 дугаар албан бичгээр сумдын Засаг дарга нарт 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл чоныг төлбөргүй агнах зөвшөөрлийг олгосон боловч энэ хугацаанд аймгийн хэмжээнд нийт 4 чоно агнасан байна. Гэвч иргэд, малчдаас ирүүлсэн “хоттой хонь руу чоно дайрах тохиолдол элбэгшиж байна” гэх гомдол, мэдээллээс үзэхэд, Ховд аймгийн хэмжээнд чонын тоо хэмжээ, нөөцийг яаралтай тогтоох шаардлагатай байна.
2. Тус аймагт чоно агнах төлбөрөөс тодорхой хугацаанд чөлөөлсөн хэдий ч аймгийн хэмжээнд нийт 4 чоно агнагдсан нь иргэд, малчид чоно агнах, барих зөвшөөрөл авахад зөвхөн төлбөрийн хэмжээнээс гадна бусад шаардлагатай баримт бичиг бүрдүүлэхэд үүсэж буй нөхцөл нь зөвшөөрөл авахгүй байх, авч чадахгүй байх шалтгаан болсон байна. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.2-т заасны дагуу чоно

агнах, барих зөвшөөрлийг **тав хүртэл** хоногийн хугацаатай олгож байгаа бөгөөд энэ хугацаанд ан хийж чадаагүй бол дахин зөвшөөрөл авах шаардлага үүсэж байна.

3. Ховд аймгийн хэмжээнд өнгөрсөн хугацаанд Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу бүртгэгдсэн тохиолдол байхгүй тул энэ хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ одоогоор байхгүй байна.

### **2.3.ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ЧОНО АГНАСАН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ ТАЛААР**

Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу дараах хариуцлагыг хүлээлгэдэг. Үүнд:

- Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи–эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг төлүүлнэ.

**Торгууль, нөхөн төлбөрийн хэмжээ:** Засгийн газрын 2023 оны “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу чонон экологи-эдийн засгийн үнэлгээг 1,130,000 сая төгрөгөөр тогтоосон байна. Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу торгууль төлөхөөс гадна Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу 2,260,000 төгрөгийн нөхөн төлбөр төлдөг.

**Зөвшөөрөлгүй чоно агнасан зөрчил:** Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 123 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэлд өнгөрсөн хугацаанд Ховд аймгийн хэмжээнд зөвшөөрөлгүй чоно агнасан 1 хэрэг бүртгэгдсэн боловч сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон байна.

*“Ховд аймгийн Мөст сумын иргэн Н-ийн мал руу 2022 оны 01 дүгээр сард чоно дайрсан бөгөөд 2 чоно зөвшөөрөлгүй агнасан байсан. Тухайн асуудлаар аймгийн Цагдаагийн газраас хэрэг үүсгэн шалгаж Мэргэжлийн хяналтын газарт харьяаллын дагуу шилжүүлсэн бөгөөд Мөст сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч уг зөрчлийн хэргийг шалгаж хэрэгсэхгүй болгосон.”*

*Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 123 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл*

Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд хүлээлгэх торгууль, төлбөрийн хэмжээг хууль тогтоомжоор тодорхой зохицуулсан боловч зөвшөөрөлгүй чоно агнасан ч торгууль, төлбөр төлж байгаагүй гэсэн иргэд, малчдын хариулт болон тус аймгийн хэмжээнд зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдол 1 удаа бүртгэгдэж уг хэрэг нь хэрэгсэхгүй болсон зэрэг практик мэдээллээс үзэхэд, зөвшөөрөлгүй ан агнах үйл ажиллагаанд тавьж буй орон нутгийн хяналт сул байна. Түүнчлэн өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдлийн соёлтой амьдарч буй малчин иргэдийн зөвшөөрөлгүй ан агнах үйл ажиллагааг бүрэн хянах боломжгүй нөхцөлийг мөн бүрдүүлжээ.

## 2.4.ГАЛТ ЗЭВСГИЙН ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ГАЛТ ЗЭВСЭГ АШИГЛАН ЧОНО АГНАСАН ЗӨРЧЛИЙН ТАЛААР

Чоно агнах зөвшөөрөлтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан үзэхэд иргэд, малчид ахуйн зориулалтаар галт зэвсэг өмчлөх, эзэмших зөвшөөрөл авахад хүндрэл үүсдэг, мөн гарцаагүй тохиолдолд амь бие, эд хөрөнгөө хамгаалж болно гэж заасан хэдий ч Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээж байгаа талаар үнэлгээ хийх явцад хөндөгдсөн тул үнэлгээний энэ хэсэгт Галт зэвсгийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлсэн болно.

**Галт зэвсгийн зөвшөөрөл:** Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол 21 нас хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, галт зэвсэг ашиглаж гэмт хэрэг санаатай үйлдэж байгаагүй, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн иргэний зориулалттай<sup>5</sup> галт зэвсэг өмчилж болно” гэж заасан.

Ховд аймгийн хэмжээнд Галт зэвсгийн тухай хуульд заасны дагуу галт зэвсгийн гэрчилгээтэй, албан ёсны өмчлөх эрхтэй 2397 иргэн, хуулийн этгээд байна.<sup>6</sup>

Галт зэвсгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Иргэний зориулалттай галт зэвсэг худалдаж авсан, улсын хилээр оруулсан иргэн ажлын арван өдрийн дотор галт зэвсгээ байнга оршин суугаа газрын нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бүртгүүлэх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлнэ” гэж заасан. Үүнд:

- галт зэвсэг бүртгүүлэхийг хүссэн өргөдөл;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- тухайн иргэний гурван хувь цээж зураг;
- галт зэвсгийн нэр, төрөл, үйлдвэрлэсэн он, дугаарыг тодорхойлсон баримт бичиг;
- улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- өмчлөх галт зэвсгийн сумны хонгио, хошууны дээжийг шүүх шинжилгээний байгууллагын адилтгал, мэдээллийн санд бүртгүүлсэн тухай тодорхойлолт;
- галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан гэрчилгээ;
- энэ хуулийн 11.6-д заасан өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудас.

**Галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалт:** Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалаар “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”-ыг баталсан байна. Тус зааврын 2.2-т “Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтыг Улаанбаатар хотод сургалтын төв, аймагт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага хариуцан зохион байгуулна” гэж заажээ.

Энэ хүрээнд Ховд аймгийн Цагдаагийн газраас 2019-2022 оны хооронд нийт 6 удаа галт зэвсэг эзэмших аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулж 150 орчим иргэнд галт зэвсгийн гэрчилгээ олгожээ.

<sup>5</sup> Галт зэвсгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Ан агнах, буудлагын спорт-сургалтаар хичээллэх, үзмэр, цуглуулгын зорилгоор Монгол Улсын иргэний өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсгийг иргэний зориулалттай галт зэвсэг гэнэ.” гэж заасан.

<sup>6</sup> Ховд аймгийн Цагдаагийн газрын Галт зэвсгийн бүртгэл хариуцсан албан тушаалтнаас Улсын Их Хурлын Тамгын газарт цахимаар ирүүлсэн мэдээлэл.

Галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын төлбөр 150,000 төгрөг, тэмдэгтийн хураамж 10,000 төгрөг, гэрчилгээний үнэ 4,800 төгрөг буюу нийт 164,800 төгрөгийн төлбөр төлдөг байна.

**Зөвшөөрөлгүй галт зэвсэг ашиглан ан хийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага:** Хэрэв иргэн, хуулийн этгээд зөвшөөрөлгүй галт зэвсэг ашигласан бол Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.4-т “Хуульд заасны дагуу сургалтад сууж гэрчилгээ аваагүй, хуульд заасан өмчлөх эрхгүй этгээд галт зэвсэг олж авсан, эзэмшсэн, ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тухайн галт зэвсгийг хурааж хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

2023 оны I улирлын байдлаар иргэн, хуулийн этгээд бүртгэлгүй галт зэвсгээр чоно агнасан тохиолдол Ховд аймгийн Цагдаагийн газарт бүртгэгдээгүй байна.

Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “...Иргэн өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа галт зэвсгээр амь бие, эд хөрөнгийг араатан, амьтнаас хамгаалах зорилгоор ашиглаж болно.” гэж заасан. Хэрэв тухайн иргэн өмчлөх зөвшөөрөл бүхий галт зэвсгээр амь, бие эд хөрөнгөө хамгаалсан бол хуулийн хариуцлага хүлээхгүй бөгөөд 2018 оноос хойш иргэн өөрийн өмчилж буй галт зэвсэг ашиглан амь бие, эд хөрөнгөө араатан амьтнаас хамгаалсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

Хуульд заасан шаардлагын дагуу иргэд, малчид ахуйн зориулалтаар галт зэвсэг өмчлөх зөвшөөрөл авахад шаардлагатай материалыг “галт зэвсгийн нэр, төрөл, үйлдвэрлэсэн он, дугаарыг тодорхойлсон баримт бичиг” бүрдүүлж өгөхөд хүндрэл үүсдэг байна. Учир нь ихэнх малчдын гар дээр үндсэн хэв загварыг нь өөрчилсөн, хуучны болон худалдаж авсан эх сурвалж, гарал үүсэл тодорхойгүй галт зэвсгүүд байдаг байна. Үүнээс шалтгаалан иргэд, малчид галт зэвсгээ чаддаггүй байна. Энэ талаар Ховд аймгийн Цагдаагийн газраас тодруулахад, гарал үүсэл тодорхойгүй, хэв загварыг нь өөрчилсөн галт зэвсгийг албан ёсны мэдээллийн санд бүртгэх боломжгүй<sup>7</sup> гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Түүнчлэн 164,800 төгрөгийн төлбөр төлж галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байх шаардлага нь иргэд, малчдын хувьд хүндрэлтэй байдаг талаар Ховд аймгийн зарим малчин иргэд дурдаж байсан.

*“Хэдэн малаа орхиод аймгийн төв рүү галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдахаар явах нь малчин бидний хувьд цаг зав, зардал мөнгөний хувьд хүндрэлтэй байдаг.”*

*Ховд аймгийн Мөст сумын иргэн Ч...*

Галт зэвсгийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг хянан үзэхэд, хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

1. Иргэд, малчид өмчлөх зөвшөөрөлгүй галт зэвсэг ашиглан амь нас, эд хөрөнгөө хамгаалсан бол Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан үйлчлэл хамаарахгүй бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.4-т заасны дагуу хариуцлага хүлээдэг. Өөрөөр хэлбэл, иргэд, малчид холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтын ялгаа, заагийг төдийлөн ойлгоогүй буюу ямар тохиолдолд хуулийн

<sup>7</sup> Ховд аймгийн Цагдаагийн газрын Галт зэвсгийн бүртгэл хариуцсан албан тушаалтнаас ирүүлсэн мэдээлэл



хариуцлага хүлээх, ямар тохиолдолд хуулийн хариуцлага хүлээхгүй байгаа талаарх хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна.

2. Иргэд, малчид галт зэвсэг өмчлөхөд Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан шалгуур, шаардлагын талаар шүүмжлэлттэй хандаж байгааг судлан үзэхэд галт зэвсэг өмчлөхөд тавигдах шалгуур, шаардлага нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэслэл бүхий зохицуулалт байна.
3. Малчдын гар дээр үндсэн хэв загварыг нь өөрчилсөн, хуучны болон худалдаж авсан эх сурвалж, гарал үүсэл тодорхойгүй галт зэвсэг байгаагаас шалтгаалан Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.4-т заасны дагуу зөрчлийн хэрэг үүсэх нөхцөл бүрдэж байна.

## **2.5.БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА БОЛОН АНГИЙН АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА ХОРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

Бүс нутгийн амьтны зүйлийн бүрдэл, тэдгээрийн тархац, нөөцийн судалгааг хийхэд мэргэжлийн байгууллагын үүрэг, оролцоо чухал байдаг тул үнэлгээний энэ хэсэгт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон ангийн аж ахуй эрхэлдэг мэргэжлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны талаар судлан үзлээ.

Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчны мэргэжлийн байгууллага дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах;
- амьтныг сэргээн нутагшуулах;
- үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;
- биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах зэрэг болно.

Мөн хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу амьтныг сэргээн нутагшуулах үйл ажиллагааг эрхэлдэг байна.

Байгаль орчны мэргэжлийн байгууллага нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасны дагуу үйл ажиллагаагаа тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлдэг бөгөөд тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор заасан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд, Монгол Улсын хэмжээнд нийт 89 мэргэжлийн байгууллага үйл ажиллагаа эрхэлж байгаагаас “Ан амьтны нөөц, тархцыг тогтоох судалгаа, агнуур зохион байгуулалт хийх, ан амьтныг сэргээн нутагшуулах, үржүүлэх туршилт-судалгааны ажил эрхлэх, ан амьтан асран хамгаалах, амьтны хүрээлэн ажиллуулах” чиглэлээр 14, ан агнуурын чиглэлээр 40 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна.

Амьтны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Агнуур зохион байгуулалтыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.” гэж заасны дагуу агнуур зохион байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, гэрээ байгуулах бөгөөд сонгогдсон мэргэжлийн байгууллага

тухайн аймгийн агнуур зохион байгуулалтыг гүйцэтгэж, 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулдаг байна.

Өнгөрсөн хугацаанд Ховд аймгийн агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг дараах мэргэжлийн байгууллагууд гэрээний үндсэн дээр гүйцэтгэжээ. Үүнд:

**Хүснэгт 2.**Ховд аймгийн агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан мэргэжлийн байгууллага

Д/д	Хамрагдах хугацаа	Гүйцэтгэсэн байгууллага	Төлөв
1.	2012-2016 оны ан агнуурын менежментийн төлөвлөгөө	“СиТиБи” ХХК	Хэрэгжиж дууссан.
2.	2017-2021 оны ан агнуурын менежментийн төлөвлөгөө	“Уламжлалт ав” ХХК	Хэрэгжиж дууссан.
3.	2022-2026 оны ан агнуурын менежментийн төлөвлөгөө	“Агнуур судлалын нийгэмлэг” ТББ	Батлуулахаар БОАЖЯ-нд хүргүүлсэн.

Мөн Ховд аймгийн хувьд судалгаа шинжилгээний чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна агнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж 2022 онд Ховд аймгийн хэмжээнд мэргэжлийн 9 аж ахуй нэгж, төрийн бус байгууллагууд нийт 52 тоо толгой аргаль, тэх, угалз, буга агнаж 1,658,348,868 орчим төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Түүнчлэн 2022 онд тус аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны үр дүнд 10 сумын 18 агнуурын бүс нутаг бий болсон бөгөөд тус агнуурын бүс нутгуудыг 1 төрийн бус байгууллага, 6 аж ахуйн нэгж, 1 хоршоо хариуцан ажиллаж байна.

## ГУРАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Ахуйн зориулалтаар саарал чоно агнахтай холбоотой харилцааг зохицуулж буй хуулиудын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Ховд аймгийн хүрээнд хийж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

### 3.1.Үнэлгээний дүгнэлт

1. Ховд аймгийн хэмжээнд **чонын тоо хэмжээ, нөөцийг судлан тогтоож байсан баримт, мэдээлэл байхгүй** буюу энэ талаар тодорхой ажил хийгдээгүй байна. Тухайлбал, 2012 оноос хэрэгжиж эхэлсэн Амьтны тухай хуульд заасны дагуу Ховд аймгийн ан агнуурын 2012-2016, 2017-2021, 2022-2026 оны агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулахдаа чонын тоо хэмжээ, нөөцийг тогтоон тусгаагүй байна;
2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/89 дүгээр тушаалаар 2022 онд тус аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар агнах, барих чонын тооны дээд хязгаарыг 50 байхаар тогтоосон нь Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасан “Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг, энэ хуулийн 5.3.2, 5.8.1-д заасан агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.” гэсэн **шаардлагыг хангаагүй байна;**



3. Тус аймгийн хэмжээнд чонын тоо хэмжээ, нөөцийг тогтоогоогүй байх тул Амьтны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.12-т заасан “эрх бүхий мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалтын ажлыг хуульд заасан хугацаанд нь хийлгээгүй аймаг, сум, нийслэл, дүүргийн нутагт агнуурын амьтан агнах, барих”-ыг хориглох заалтын үйлчлэлд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, Ховд аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар чоно агнах, барих **хуульд заасан нөхцөл бүрдээгүй байна;**
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь хэсэгт заасан “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх...” нөхцөлийг Ховд аймгийн хэмжээнд **хэрхэн тогтоосон нь тодорхойгүй** байхад тус заалтыг үндэслэн Ховд аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/212 дугаар албан бичгээр сумдын Засаг дарга нарт хандан чоныг төлбөргүй агнах зөвлөмжийг хүргүүлсэн байна;
5. Өнгөрсөн хугацаанд Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан “Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэргэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно.” гэж заасан боловч Ховд аймгийн хэмжээнд чонотой холбоотой тус заалтад хамаарах **нөхцөл тогтоогдож бүртгэгдээгүй** байх тул тус заалтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ одоогоор байхгүй байна;
6. Тус аймагт чоно агнах төлбөрөөс тодорхой хугацаанд чөлөөлсөн хэдий ч аймгийн хэмжээнд нийт 4 чоно агнагдсан нь иргэд, малчид чоно агнах, барих зөвшөөрөл авахад зөвхөн төлбөрийн хэмжээнээс гадна бусад шаардлагатай баримт бичиг бүрдүүлэхэд үүсэж буй нөхцөл нь зөвшөөрөл авахгүй байх, авч чадахгүй байх шалтгаан болсон байна. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.2-т заасны дагуу чоно агнах, барих зөвшөөрлийг **тав хүртэл** хоногийн хугацаатай олгож байгаа бөгөөд энэ хугацаанд ан хийж чадаагүй бол дахин зөвшөөрөл авах шаардлага үүсэж байна;
7. Зөвшөөрөлгүй чоно агнасан ч торгууль, төлбөр төлж байгаагүй гэж хариулсан иргэд, малчдын мэдээлэл болон тус аймгийн хэмжээнд зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдол 1 удаа бүртгэгдэж уг хэрэг нь хэрэгсэхгүй болсон зэрэг практик мэдээллээс үзэхэд, зөвшөөрөлгүй ан агнах үйл ажиллагаанд тавьж буй **орон нутгийн хяналт сул байна;**
8. Иргэд, малчид өмчлөх зөвшөөрөлгүй галт зэвсэг ашиглан амь нас, эд хөрөнгөө хамгаалсан бол Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан үйлчлэл хамаарахгүй буюу Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.4-т заасны дагуу хариуцлага хүлээдэг. Харин агнах, барих зөвшөөрөлгүй чоно агнасан, барьсан бол Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээдэг. Өөрөөр хэлбэл, малчдын хоттой хоньруу чоно дайрсан тохиолдолд **зөвшөөрөлтэй галт зэвсгээр** амь нас, эд хөрөнгөө хамгаалсан бол зөрчил үүсэхгүй бөгөөд харин **зөвшөөрөлгүй галт зэвсгээр** амь нас, эд хөрөнгөө хамгаалсан бол Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээх зохицуулалттай. Иймд иргэд, малчид холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтын ялгаа, заагийг төдийлөн ойлгоогүй байна;
9. Малчдын гар дээр үндсэн хэв загварыг нь өөрчилсөн, хуучны болон худалдаж авсан эх сурвалж, гарал үүсэл тодорхойгүй галт зэвсэг байгаагаас шалтгаалан Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 5.6.4-т заасны дагуу **зөрчлийн хэрэг үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна;**

10. Иргэд, малчид галт зэвсэг өмчлөхөд Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан шалгуур, шаардлагын талаар шүүмжлэлттэй хандаж байгааг судлан үзэхэд галт зэвсэг өмчлөхөд тавигдах шалгуур, шаардлага нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн **үндэслэл бүхий зохицуулалт байна**;
11. Ахуйн зориулалтаар чоно агнах, барихтай холбоотой Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны тухай хууль, Галт зэвсгийн тухай болон Зөрчлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын талаарх **иргэд, малчдын мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна**;
12. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгаль орчны **мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилласан байна**.

### 3.2. Үнэлгээний зөвлөмж

1. Ховд аймгийн хэмжээнд чонын тоо хэмжээ, нөөцийг холбогдох хууль тогтоомжийн дагуу судлан тогтоосны үндсэн дээр тухайн жилд ахуйн зориулалтаар агнах, барих чонын тоо хэмжээг тогтоож байх;
2. Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2-т заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах;
3. Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад тусгасан нөхцөл байдал үүссэн эсэхийг мэргэжлийн байгууллага тогтоосны үндсэн дээр холбогдох шийдвэрийг гаргаж байх;
4. Галт зэвсэг зөвшөөрөлгүй өмчлөх болон зөвшөөрөлгүй чоно агнах үйл ажиллагаанд хяналт тавих мэргэжлийн байгууллагын хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх;
5. Малчдын гар дээр байгаа үндсэн хэв загварыг нь өөрчилсөн, хуучны болон худалдаж авсан эх сурвалж, гарал үүсэл тодорхойгүй галт зэвсгийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу илрүүлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;
6. Ховд аймгийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь байгаль орчны мэргэжлийн байгууллагатай хамтран ахуйн зориулалтаар чоно агнах, барих үйл ажиллагаатай холбоотой Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны тухай хууль, Галт зэвсгийн тухай болон Зөрчлийн тухай хуульд заасан холбогдох зохицуулалтын талаарх мэдлэг, мэдээллийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;
7. Ховд аймгийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргаан байгууллага нь байгаль орчны мэргэжлийн байгууллагатай хамтран сүүлийн жилүүдэд Ховд аймагт судлагдаагүй ан агнуурын амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулах.